

БАТЛАВ  
БААЦАГААН СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ  
ДАРГА *Х.Баянмөнх* Х.БАЯНМӨНХ

БАЯНХОНГОР АЙМГИЙН БААЦАГААН СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ 2020-2024 ОНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 06 сарын 24

Баацагаан

**НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**1.1 Орлоготой иргэн**

- 1.1.1 Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэд, их дээд сургуулиудтай хамтарч "Технологи, инновац, судалгаа шинжилгээний төв" байгуулах замаар орон нутгийн төвшинд хөгжих боломжтой үйлдвэрүүдийг тодорхойлж үйлдвэржилтийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.1.2 "Хуримтлалтай хонгорчууд" хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж "Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох "Хуримтлалтай хүүхэд" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.3 Сүү цагаан идээ боловсруулах фермерүүдийг 7 багийн төвлөрсөн айлуудын голд байгуулж борлуулалтын БНХАУ-ын Шилэн хотод борлуулснаар малын гаралтай бүх түүхий эдийг эргэлтэд оруулж, 1 баг дээр 8 хүн ажлын байртай болгох нийт 7 багийн 56 хүн ажлын байртай болгох
- 1.1.4 Хонины нэхий, үхрийн шир элддэг үйлдвэр байгуулж 12 хүн ажлын байртай болгож, борлуулалтыг Оросын Холбооны Улсын Якутад борлуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.1.5 Хонины ноос худалдан авч эсгийний үйлдвэр, цех байгуулна
- 1.1.6 Ажилд зуучлагч төрийн бус байгууллага байгуулж ажилгүй иргэдийг Улаанбаатар хот болон аймагт ажлын байранд зуучилна.
- 1.1.7 Бөөнцагаан нууранд байгалийн элс шавраар түшиглэн сувиллын газар байгуулж нутгийн 70-аас дээш настнуудыг үнэ төлбөргүй жилд нэг удаа сувилалд амраана.
- 1.1.8 Суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудын зардлаар ажилгүй иргэдийг сургаж, ажлын байраар хангана.

**1.2 Хуримтлалын нэгдсэн сан ба орон сууцтай өрх**

- 1.2.1 Сумын шинэчлэлийг 2021 оноос эхлүүлж, сумын төвийн бүх айлыг халуун, хүйтэн ус, бохирын шугамд холбоно.
- 1.2.2 Хуучин засаг даргын тамгын газрын байрыг засаж хүүхдээ хардаг эцэг эхчүүдэд бага түрээсээр түрээсэлж, түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2.3 Хуучин клубийг засварлаж стандарт хангасан буудал болон зоогийн газар байгуулна.



000000001

- 1.2.4 Хуучин эмнэлгийн барилгыг засварлаж жижиг дунд үйлдвэрлэлийн байр болгож ажлын байраар хангана.
- 1.2.5 Мах боловсруулах жижиг цех байгуулж 20 тн мах хөлдөөх хөргүүртэй зоорь байрлуулж, иргэдийг хаврын цагт шинэ махаар хангана.



### 1.3 Эрүүл иргэн

- 1.3.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааны “Жишиг загвар төв” байгуулна.
- 1.3.2 Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, орон нутгийн болон бүх шатлалын эмнэлгүүдийн оношилгоо, мэдээллийг дотоодод болон олон улсад цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.3.3 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлж, “Элэг бүтэн Баянхонгор” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.4 Бүх иргэдээ эрүүл мэндийн нэгдсэн үзлэг оношилгоонд хамруулж хүний эрүүл мэндийн нэгдсэн сантай болно.

### 1.4 Чанартай боловсрол

- 1.4.1 Боловсролын салбарын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ
- 1.4.2 Баацагаан сумын 90 ортой хүүхдийн цэцэрлэгийн их засварыг хийж ашиглан, яслийн бүлэгтэй болж цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэн орчны стандартыг хангана.
- 1.4.3 Хүүхдийн тоглоомын талбайг шинэчлэн тоглоомоор хангана
- 1.4.4 Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарыг сайжруулж, удирдлага мэдээллийн шинэчлэл хэрэгжүүлнэ.
- 1.4.5 Багшийн хөгжил ур чадварыг үнэлэх, хүүхдэд эзэмшүүлсэн мэдлэг чадварын үнэлгээгээр багшийг урамшуулах баримт бичгийг боловсруулан сайн багшийг мэргэжилдээ өсөх хөгжих, туршлага судлах гэх мэт бүх талын дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.6 Хүүхдийн хөгжих, нийгэмших, харилцаа ёс суртахууны хувьд төлөвших нөхцөлд эерэг нөлөө үзүүлэх орчин бий болгож соён гэгээрүүлэх чиглэлийн хичээл сургалтыг тогтмол оруулна.
- 1.4.7 Хүүхэд залуусын спорт хөгжлийн төв, спортын төрлүүдийн гадна хөл бөмбөгийн талбайтай болно
- 1.4.8 Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.4.9 Улаанбаатар хотод мэргэжил эзэмшсэн, эзэмшиж буй иргэдийн мэдээллийн санг бүрдүүлж, тэдний орон нутагтаа хөдөлмөрлөх, бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ
- 1.4.10 Гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг боловсронгуй болгож, гэр бүл төлөвлөлтийг сайжруулсан бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ

8417143  
A00679

000000002

- 1.4.11 Хүүхэд, багачуудын бие даах чадварыг нэмэгдүүлж, хөгжүүлж, тэдний төлөвшлийг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 1.4.12 Залуучуудын хөгжил төлөвшлийг сайжруулж, нийгмийн оролцоог нэмэгдүүлж, идэвхтэй амьдралыг нь дэмжсэн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.4.13 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, нийгмийн хамгаалал, хөгжлийг сайжруулах” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.4.14 Ахмад настанд үзүүлэх үйлчилгээг сайжруулах, хөнгөлөлт эдлүүлэх, дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэхэд төрийн зүгээс үйлчилгээ үзүүлэх журам боловсруулан хэрэгжүүлнэ
- 1.4.15 Ахмад настны амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, хөгжих төвийг байгуулан Ахмадын холбооны үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
- 1.4.16 Уламжлалт зан үйл, монгол соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх зан заншлын өргөө байгуулж, хүүхэд хөгжлийн төвүүдэд шаардлагатай сургалт, танин мэдэхүйн дэмжлэг үзүүлнэ

### ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1 “Тунгалаг санхүү” хөтөлбөр, “Хуримтлалтай Баацагаанчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.2 Хог хаягдал дахин боловсруулах, Мах боловсруулах, барилгын блок тоосго материал үйлдвэрлэх, арьс шир боловсруулах, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах, оёдлын үйлдвэр зэрэг жижиг үйлдвэрүүдийг байгуулна. Талх нарийн боовны үйлдвэр байгуулна
- 2.3 Бөөнцагаан нуур чиглэлийн аяллын жуулчлалыг хөгжүүлж, жилд ирэх жуулчдын тоог нэмэгдүүлж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.4 Утаагүй-Баацагаан төслийг хэрэгжүүлж сумын төвийн гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн дулаан, цэвэр, бохирын шугам сүлжээнд холбож орчны бохирдлыг бууруулна.
- 2.5 Сум шинэчлэх хөтөлбөр хэрэгжүүлж, сумын төвийн айл өрхийг инженерийн шугам сүлжээгээр холбож, гудамж хорооллын замын гэрэлтүүлгийг сайжруулна.
- 2.6 Сумын төвийн дотоодод төв замтай холбосон 1.2 км авто замыг барих ажлыг эхлүүлнэ. Мөн 800 м явган хүний зам, дугуйн замтай болно

### ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 3.1 Төрийн байгууллага бүрд төрийн албан хаагчийн “Нийгмийн баталгааг хангах” хөтөлбөр, төрийн албан хаагчийн “Сургалтын хөтөлбөр”-ийг батлуулан хэрэгжүүлж, “Орон сууц хашаа байшин худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх” журмыг хэрэгжүүлэх ажлыг жил бүр зохион байгуулна.
- 3.2 Төрийн албаны шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих боломж бүхий цахим системийг нэвтрүүлэх, Төрийн үйлчилгээг операторын үйлчилгээнд шилжүүлж, үйл ажиллагааг нь чанаржуулж тогтмолжуулна.
- 3.3 Баацагаан сумын 2-оос доошгүй хөдөө багийн төвийг эрчим хүчинд холбох ажлыг эхлүүлнэ.




000000003

544  
007423

## ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 4.1 Усны нөөц, голуудын урсац бүрэлдэх эхийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авна
- 4.2 Сумын төвийн хойд талын цэцэрлэгийн ногоон байгууламжийг 20 га гаар нэмэгдүүлж "Ногоон Баацагаан" ажил арга хэмжээг хэрэгжүүлнэ
- 4.3 "Хашаандаа сайхан амьдаръя" төслийг хэрэгжүүлж хашаандаа хүнсний ногоо тариалахыг бодлогоор дэмжинэ.

## ТАВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 5.1 Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх "Илгээлтийн эзэн-III" аяныг хэрэгжүүлнэ.
- 5.2 "Монгол мал-2" хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, малын гений санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ
- 5.3 Махны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор гахай, тахианы аж ахуй байгуулах санал, санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 5.4 Мах, сүүний чиглэлийн мал үржүүлэх бүс нутгуудын малыг эрүүлжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрч, "Эрүүл бүс" нутагт тавигддаг олон улсын шаардлагуудыг хангаж зах зээлд зарлана.
- 5.5 Баацагаан сумын Хөх эрэгт тэжээлийн ургамал тариална.
- 5.6 Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг жил бүр зохион байгуулж талхагдалтыг бууруулна
- 5.7 Бэлчээрийг зохистой ашиглах, малын тоо толгойг зохист төвшинд барих, мал махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого гаргаж "Бэлчээр ашиглалтын журам"-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 5.8 Ган гачгийн нөлөөллийг бууруулах чиглэлээр хөдөө аж ахуйн олон улсын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, шаардлагатай бол үүлэнд зориудаар нөлөөлөх ажлыг жил бүр хэрэгжүүлж ажиллана.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_




000000004